

2026 ОНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Огноо: 2026.01.15

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Улирал	Хариуцах нэгж
1	Нийгмийн даатгалын үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай үзүүлэх, хөгжүүлэх, сайжруулах, цахимжуулах, нийгмийн даатгалын маркетингийг боловсронгуй болгох, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэдгээрийн шинэчлэлийн талаар мэдээлэх, сурталчлах, олон нийтэд түгээх;	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	47	I-IV улирал	ҮХОНХГ
2	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн хэрэглээг сайжруулах зорилгоор иргэд, даатгуулагч, ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэх, сайжруулах санал боловсруулж, хэрэгжүүлэх;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Оролцогчийн тоо	Арга хэмжээ -4, Оролцогчид- АО-6000 И,Д-1800	I-IV улирал	ҮХОНХГ
3	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэх, сайжруулах санал боловсруулж, хэрэгжүүлэх;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Оролцогчийн тоо	Арга хэмжээ- 2, Оролцогчид- 2040	I-IV улирал	ҮХОНХГ
4	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, сайжруулах, хөгжүүлэх;	Дуудлага алдалтын хувь	Аймаг-10%, Дүүрэг-15%	I-IV улирал	ҮХОНХГ
5	Нийгмийн даатгалын сангаас олгох зарим төрлийн тэтгэврийг цахимаар хүсэлт гаргах боломжийг бүрдүүлэх;	Үйлчилгээний тоо	4	II-IV улирал	ҮХОНХГ БХТГ, МТТ
6	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар гаргах боломжийг бүрдүүлэх;	Үйлчилгээний тоо	4	II-IV улирал	ҮХОНХГ БХТГ, МТТ
7	Нийгмийн даатгалын байгууллагын ажлын байр, үйлчилгээний орчны стандартыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, үнэлгээ өгөх, өөрчлөлт оруулах;	Хяналт тавьж, үнэлгээ өгсөн аймаг, дүүргийн тоо	Аймаг-2, Дүүрэг-7	I-II улирал	ҮХОНХГ
8	Иргэд даатгуулагч, ажил олгогчдоос цахим хэлбэрээр ирүүлсэн асуулт, санал шүүмж, хүсэлт, гомдол, талархалд дүн шинжилгээ хийх;	Цахимаар ирүүлсэн асуулт, санал шүүмж, хүсэлт, гомдол, талархлын тоо, Дүн шинжилгээ хийж тайлагнасан тоо	Цахимаар ирүүлсэн асуулт, санал шүүмж, хүсэлт, гомдол, талархлын тоо-3200, Дүн шинжилгээ хийж тайлагнасан тоо -2	I- IV улирал	ҮХОНХГ
9	Хиймэл оюун ухаанд суурилсан чатбот үйлчилгээг нэвтрүүлэх;	Хэрэгжүүлсэн ажил	1	I-II улирал	ҮХОНХГ
10	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэд, даатгуулагчдад ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент хүргэх;	Мэдээлэл бэлтгэсэн тоо Хандалтын тоо Дагагчдын тоо	Мэдээлэл бэлтгэсэн тоо-400, Хандалтын тоо-100.000.000, Дагагчдын тоо-187.000	I-IV улирал	ҮХОНХГ
11	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр төрийн болон олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;	Хамтран ажилласан байгууллагын тоо	Хамтран ажилласан байгууллагын тоо - 15	I-IV улирал	ҮХОНХГ
12	Нийгмийн даатгалын байгууллагын үзүүлсэн үйлчилгээ, орлого, зарлагыг мэдээлэх “Мэдээллийн цаг”-тай болох	Мэдээллийн цаг зохион байгуулсан тоо	5	III-IV улирал	ҮХОНХГ

